



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 10 сарын 27 өдөр

Дугаар 9/449

Мандлговь

Барилга байгууламжийг ашиглалтад
оруулах комисс ажиллуулах тухай

Монгол Улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6 дахь заалт, Засгийн газрын 2017 оны 03 дугаар сарын 07-ны өдрийн 69 дүгээр тогтоолоор баталсан "Барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрэм"-ийн 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Дундговь аймгийн Адаацаг сумын Ерөнхий боловсролын Сургууль болон дотуур байрны уурын зуухны дулааны шугамын шинэчлэн засварлах ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын дарга:	Н.Эрдэнэ-Очир	(Аймгийн ЗДТГазрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Нарийн бичгийн дарга:	О.Мөнхзул	(Аймгийн ЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн)
Гишүүд:	А.Бямбаа	("Мандал харш" ХХК-ний инженер)
	Н.Эрдэнэбат	(Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн)
	Э.Түвшинтөгс	("Алтан бат өрлөг" ХХК-ний захирал)
	Ж.Энхтуул	(Адаацаг сумын Сургуулийн захирал)
	П.Алтанчимэг	(Аймгийн ЗДТГ-ын Архивын тасгийн дарга)

Хоёр. Угсралтын ажлыг хууль, дүрмийн дагуу ажиллаж, зураг, төслийн дагуу гүйцэтгэсэн байдалд дүгнэлт гарган, архивт хүлээлгэн өгч мэдээллийн нэгдсэн санд бүртгүүлэхийг комисс (Н.Эрдэнэ-Очир)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН ОРЛОГЧ



Ж.МӨНХЧУЛУУН

433010413